# ОРХОН АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 17 -ны өдөр Дугаар А/43 Эрдэнэт

Хандив тусламжаар ирсэн эм хуваарилах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дах заалт, Иргэний хуулийн 276.6 дах заалт, 2022 оны 05 дугаар сарын 16 өдрийн Бамбай фарм ХХК-ын “Хамтран ажиллах тухай” А/22-5/3 албан тоотыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бамбай фарм ХХК-аас хандивласан томуу, томуу төст өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, шинж тэмдэгийн эмчилгээнд хэрэглэх ханиадны эсрэг эм болон артерийн даралт ихсэх өвчний үед хэрэглэх Аллерин 60мл №1, Амло-денк 5мг №50 эмүүдийг Эрүүл мэндийн байгууллагуудад өгөх хуваарийг нэгдүгээр, аллерин 60мл №1 сироп эмийн хэрэглэх зааврыг хоёрдугаар, зарцуулалтын тайлангийн маягтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагуудад олгох хуваарь гаргаж, зарцуулалтын тайланд хяналт тавихыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн /О.Анхбаяр/-т, хуваарийн дагуу Эрүүл мэндийн байгууллагуудад олгох, баримтжуулахыг нярав /Б.Алтанзагас/-д тус тус үүрэг болгосугай.

3. Хандиваар олгосон эмийн олголт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ХШҮДАХ мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

9043446 2020030036

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны .05. .-р сарын .17. . .-ны
. . . . . өдрийн А/43 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

## БАМБАЙ ФАРМ ХХК-ЫН ХАНДИВЛАСАН ЭМИЙН ХУВААРИЛАЛТ

| № | Эрүүл мэндийн байгууллагын нэр | Аллерин 60мл | | | Амло-денк 5мг №50 | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ | |
| 1 | Эрүүл мэндийн газар | - | 6,500 | - | 2 | 22,000 | 44,000 | 44,000 |
| 2 | БОЭТ | 300 | 6,500 | 1,950,000 | 22 | 22,000 | 484,000 | 2,434,000 |
| 3 | Анхны-Оч ӨЭМТ | 30 | 6,500 | 195,000 | - | - | - | 195,000 |
| 4 | Мэндцэцэн ӨЭМТ | 30 | 6,500 | 195,000 | - | - | - | 195,000 |
| 5 | Мөнхсүндрэл ӨЭМТ | 26 | 6,500 | 169,000 | - | - | - | 169,000 |
| 6 | Нийцэл ӨЭМТ | 26 | 6,500 | 169,000 | - | - | - | 169,000 |
| 7 | Үйлсбадрах ӨЭМТ | 30 | 6,500 | 195,000 | - | - | - | 195,000 |
| 8 | Мөнхийн гэгээ ӨЭМТ | 26 | 6,500 | 169,000 | - | - | - | 169,000 |
| 9 | Энхжих мандариваа ӨЭМТ | 26 | 6,500 | 169,000 | - | - | - | 169,000 |
| 10 | Учралтбаяр ӨЭМТ | 26 | 6,500 | 169,000 | - | - | - | 169,000 |
| 11 | Жаргалант сум ӨЭМТ | 16 | 6,500 | 104,000 | - | - | - | 104,000 |
| БҮГД | | 536 | | 3,484,000 | 23 | | 528,000 | 4,012,000 |

Хуваарь гаргасан: ЭБХЧАБЗХХМэргэжилтэн О.Анхбаяр

Хянасан: ССБМНБАжилтан Н.Чулуун-Эрдэнэ

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны ..05..-р сарын .17. .-ны
. . . . . өдрийн А/43 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**Бэлдмэлийн худалдааны нэр : АЛЛЕРИН ЭКСПЕКТОРАНТ,
ALLERIN EXPECTORANT.**

Хэрэглэх заавар

**Найрлага**

5 мл цайны халбага сиропд :
Дифенгидрамин HCl……………………………………………………………….12.5 мг
Гвайфенезин……………………………………………………………………… 50 мг
Натри цитрат……………………………………………………………………...180 мг
Псевдоэфедрин HCl…………………………………………………15мг агуулагдана.

**Хэрэглэх заалт:**

Харшлын гаралтай ханиад, амьсгалын замын болон хамрын салстын харшил үрэвсэл , цэр тогтонгошил, хамар битүүрэлт, амьсгалын замын халдварын шалтгаант цэртэй ханиад , ханиад шуухинааны үеийн шинж тэмдгийн эмчилгээнд хэрэглэнэ.

**Хэрэглэх арга ба тун:**

Насанд хүрэгсэд.....................................................................10мл /2 цайны халбага/ сиропыг өдөрт 3 удаа
Хүүхэд 6-12 настай............................................................ 5мл /1 цайны халбага/ сиропыг өдөрт 3 удаа ууна.

**Гаж нөлөө:**

Тайвшруулах, ходоод гэдэсний хямрал, толгой өвдөх, нойргүйтэх, сэтгэл түгших, чичрэх, тахикарди, зүрхний хэм алдах, ам хуурайших, зүрх дэлсэх, шээсний замын хямрал илэрч болно.

**Хориглох заалт:**

Эмийн найрлага дах бодист хэт мэдрэг өвчтөнд хэрэглэхгүй.

**Анхааруулга:**

- Элэгний болон бөөрний үрэвсэл, нүдний даралт ихсэх өвчин, түрүү булчирхай томрох, бамбай булчирхайн эмгэгүүд, зүрхний өвчин, багтраа, чихрийн шижинтэй өвчтөнүүд хэрэглэхээс өмнө эмчээс зөвлөгөө авах.
- 6 наснаас доош насны хүүхэд , жирэмсэн болон хөхүүл эхчүүд эмчийн зааврааар хэрэглэнэ.
- Сэтгэл заслынболон нойрсуулах эм хэрэглэж байгаа өвчтөнүүд бэлдмэлийг хэрэглэхгүй.

**Эмийн харилцан үйлчлэл :**

Моноаминоксидаз ингибитор (MAO) тайвшруулах бэлдмэлүүдтэй хамт хэрэглэхэд зүрх судасны хямралд хүргэж болно.
**Савлалтын хэлбэр** :60мл савтай. **Хадгалах нөхцөл** :30$^0$С доош хэмд хадгална. **Эмийн сангаас олгох нөхцөл** :Эмчийн жороор олгоно .
**Үйлдвэрлэгч:** PT Darya Varia Lab. Indonesia.

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны .05. .-р сарын .17. .-ны
. . . . өдрийн А/43 тоот тушаалын гуравдугаар хавсралт

9043446 2020030036

# ХАНДИВААР ХУВААРИЛАСАН ЭМИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН НЭР: ..........................................

| № | Эмийн нэр | Хэмжих нэгж | Хүлээн авсан тоо ширхэг | Зарцуулсан тоо ширхэг | Үлдэгдэл тоо ширхэг | Ямар үйл ажиллагаанд зарцуулсан | Зарцуулсан хүний гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |

Хөтөлсөн: ........................................

Хянасан: ...........................................